ЗАВХАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН  АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Түдэвтэй сумын соёлын төвийн  2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

**Аудитын код: ЗАА-2022/176/СТА-ТШЗ**

Цахим хуудас:
www.audit.mn

Улиастай сум

2022 он

Завхан аймаг дахь Төрийн Аудитын газрын
тэргүүлэх аудитор: Д.Бат-Ундраа
Утас: 99993365
Цахим хаяг: Bat-Undraa@audit.gov.mn
Аудитын менежерийн үүргийг түр
орлон гүйцэтгэгч: Г.Заяа
Утас:92038288
Цахим хаяг: zayag@audit.gov.mn
Аудитор:Ц.Алтантуул
Утас: 91195554
Цахим хаяг : tuul9565@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

**Агуулга**


1. Аудитын санал дүгнэлт ........................................ **Error! Bookmark not defined.**
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл ........................................ 4
3. Аудитын тайлан........................................ 8
   3.1 Ерөнхий зүйл........................................ 8
   3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт ........................................ 8
   3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал ........................................ 9
   3.4 Материаллаг байдал ........................................ 9
   3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга........................................ 9
   3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв........................................ 9
   3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг........................................ 10
   3.8 Аудитын гол асуудал ........................................ 10
   3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал ........................................ 10
   3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт ........................................ 11
   3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал........................................ 11
4. Аудитын илрүүлэлт ........................................ 11
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл ........................................ 12


**Товчилсон үгийн жагсаалт**

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| ТӨБЗГ | Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар |

ЗАВХАН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
81000 Улиастай, Завхан аймаг
Утас/Факс:7046-36-12

2022.02.28 № 1302/134

танай ______ -ны № ______ -т

ТҮДЭВТЭЙ СУМЫН СОЁЛЫН
ТӨВИЙН ЭРХЛЭГЧ
Б.ОТГОНБААТАР-т

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

**Хязгаарлалттай дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Түдэвтэй сумын соёлын төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан алдаа, зөрчлийн үр нөлөөг эс тооцвол Түдэвтэй сумын соёлын төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

*8.5 мянган төгрөгийн зардлыг эдийн засгийн ангиллын дагуу зарцуулаагүй, 1,245.0 мянган төгрөгийн зардлын анхан шатны баримтыг бүрэн бүрдүүлээгүй зэрэг зөрчил нь Сангийн сайдын 190, 276 дугаар тушаалууд, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.4, 13.7 дахь заалттай тус тус нийцэхгүй байна.*

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

013023063

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Д.БАТ-УНДРАА

## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан /сая төгрөгөөр/

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | 13.76 | 13.62 |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | 13.76 | 13.62 |
| **354** | **Хангамжийн материал** | 13.76 | 13.62 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 0.06 | 0.07 |
| 35420 | Аж ахуйн материал | 0.08 | 0.55 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 13.63 | 13.00 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | 83.12 | 58.22 |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 83.12 | 58.22 |
| **392** | **Биет хөрөнгө** | 79.91 | 55.01 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 88.91 | 88.91 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | (49.31) | (67.09) |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 41.70 | 41.70 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (30.84) | (36.50) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 16.07 | 16.07 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (11.80) | (13.31) |
| 39217 | Ном | 25.18 | 25.24 |
| **393** | **Биет бус хөрөнгө** | 3.21 | 3.21 |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 3.21 | 3.21 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | 96.88 | 71.84 |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | 96.88 | 71.84 |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 96.88 | 71.84 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 67.02 | 67.02 |
| 51101 | Өмч: - төрийн | 67.02 | 67.02 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | (45.47) | (70.51) |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | (45.47) | (45.47) |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | - | (25.04) |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 75.33 | 75.33 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | 96.88 | 71.84 |

### 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан / сая төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН** | 92.49 | 91.99 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | 92.49 | 91.99 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 91.99 | 91.99 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 91.99 | 91.99 |

| | | | |
|---|---|---|---|
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | 119.22 | 117.03 |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 119.22 | 117.03 |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 115.68 | 116.99 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 53.27 | 52.97 |
| 210101 | Үндсэн цалин | 49.37 | 41.71 |
| 210102 | Нэмэгдэл | 3.90 | 11.26 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 6.66 | 6.88 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 4.53 | 4.77 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 0.53 | 0.53 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 0.42 | 0.42 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 0.11 | 0.10 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 1.07 | 1.06 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 25.63 | 0.04 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 0.32 | 0.04 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 2.80 | 31.40 |
| 210401 | Бичиг хэрэг | 0.06 | 0.04 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 0.19 | 0.24 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 0.12 | 31.12 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 0.20 | 0.74 |
| 210604 | Урсгал засвар | 0.20 | 0.74 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 26.33 | 24.96 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 26.33 | 24.96 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 3.54 | 0.04 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 3.04 | 0.04 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 3.04 | 0.04 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | (26.73) | (25.04) |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | (26.73) | (25.04) |

## 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан /сая төгрөгөөр/

| **Код** | **Үзүүлэлт** | **Засгийн газрын оруулсан капитал** | **Дахин үнэлгээний нөөц** | **Хуримтлагдсан дүн** | **Засгийн газрын хувь оролцооний нийт дүн** |
|---|---|---|---|---|---|
| C01 | **2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | 63.80 | 0.80 | 7.90 | 72.50 |
| C03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | 63.80 | 0.80 | 7.90 | 72.50 |
| C07 | Тайлант үеийн үр дүн | - | - | (3.37) | (3.37) |
| C08 | **2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | 67.02 | 75.33 | (45.47) | 96.88 |
| D01 | **2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | 67.02 | 75.33 | (45.47) | 96.88 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| D03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | 67.02 | 75.33 | (45.47) | 96.88 |
| D07 | Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү | - | - | - | - |
| D08 | Тайлант үеийн үр дүн | - | - | (25.04) | (25.04) |
| D09 | **2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | 67.02 | 75.33 | (70.51) | 71.84 |

## 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/ сая төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН** | 92.49 | 91.99 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | 92.49 | 91.99 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 91.99 | 91.99 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 91.99 | 91.99 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | 92.49 | 91.93 |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 92.49 | 91.93 |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 88.95 | 91.89 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 53.27 | 50.16 |
| 210101 | Үндсэн цалин | 49.37 | 38.19 |
| 210102 | Нэмэгдэл | 3.90 | 11.97 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 6.66 | 9.69 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 4.53 | 7.71 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 0.53 | 0.49 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 0.42 | 0.39 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 0.11 | 0.10 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 1.07 | 0.99 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 27.02 | 28.92 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 0.63 | 0.82 |
| 210302 | Түлш, халаалт | 26.36 | 28.07 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 0.03 | 0.03 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 0.56 | 0.59 |
| 210401 | Бичиг хэрэг | 0.06 | 0.07 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 0.19 | 0.24 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 0.21 | 0.23 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 0.04 | 0.05 |
| **2105** | **Нормативт зардал** | 0.10 | 0.10 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 0.10 | 0.10 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 0.15 | 0.15 |
| 210604 | Урсгал засвар | 0.15 | 0.15 |

| | | | |
|---|---|---|---|
| **2107** | **Томилолт, зочны зардал** | - | 0.25 |
| 210702 | Дотоод албан томилолт | - | 0.25 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 1.20 | 2.04 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 1.07 | 1.91 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 0.13 | 0.12 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 3.54 | 0.04 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 3.04 | 0.04 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 3.04 | 0.04 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | - | 0.06 |
| **5** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)** | - | 0.06 |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | - | 0.06 |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | - | 0.06 |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | - | 0.06 |
| **6** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)** | - | (0.06) |

### 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан / сая төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | 91.99 | 91.95 |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 91.99 | 91.95 |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 91.99 | 91.95 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 49.36 | 50.16 |
| 210101 | Үндсэн цалин | 44.59 | 38.19 |
| 210102 | Нэмэгдэл | 4.77 | 11.97 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 9.69 | 9.69 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 7.71 | 7.71 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 0.49 | 0.49 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 0.39 | 0.39 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 0.10 | 0.10 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 0.99 | 0.99 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 29.72 | 28.92 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 0.82 | 0.82 |
| 210302 | Түлш, халаалт | 28.87 | 28.07 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 0.03 | 0.03 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 0.65 | 0.65 |
| 210401 | Бичиг хэрэг | 0.06 | 0.07 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 0.25 | 0.24 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 0.24 | 0.23 |
| 210404 | Ном, хэвлэл | 0.06 | 0.06 |

| | | | |
|---|---|---|---|
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 0.04 | 0.05 |
| **2105** | **Нормативт зардал** | 0.10 | 0.10 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 0.10 | 0.10 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 0.15 | 0.15 |
| 210604 | Урсгал засвар | 0.15 | 0.15 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 0.28 | 0.25 |
| 210702 | Дотоод албан томилолт | 0.28 | 0.25 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 2.04 | 2.04 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 1.91 | 1.91 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 0.13 | 0.12 |
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 91.99 | 91.99 |
| **1320** | **ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 91.99 | 91.99 |
| 132001 | Орон нутгийн төсвөөс | 91.99 | 91.99 |

## 3. Аудитын тайлан

### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Түдэвтэй сумын Соёлын төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд нягтлан бодох бүртгэл,тайлагнал, худалдан авалт, арвилан хэмнэлт зэрэгтэй холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Интер Аудит ХХК-ийн гэрээт аудитор Ц.Алтантуул гүйцэтгэж, хяналтыг Интер Аудит ХХК-ийн гүйцэтгэх захирал Ч.Мөнхбаяр, Завхан аймаг дахь Төрийн аудитын газрын аудитын менежерийн үүрэг гүйцэтгэгч Г.Заяа, дарга, тэргүүлэх аудитор Д.Бат-Ундраа нар хэрэгжүүлсэн.

Түдэвтэй сумын Соёлын төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Завхан аймаг дахь Төрийн Аудитын газарт 2022 оны 02 дугаар сарын 08-ны өдрийн 02 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Түдэвтэй сумын Соёлын төв нь Соёл урлагийн үйл ажиллагааг үйлчлүүлэгчийн хэрэгцээ, мэргэжлийн стандартад нийцүүлэн аюулгүй тав тухтай орчинд тэгш хүртээмжтэй үйлчилгээг үзүүлэх зорилго тавин ажиллаж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй байна.

Тус байгууллага нь Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг болон дотоод хяналтыг хэрэгжүүлэх журам, заавар зэргийг боловсруулж мөрдөөгүй

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитороос шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Түдэвтэй сумын Соёлын төвийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэль сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлалтай гэж үнэлсэн.

### 3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны нийт зардлын 91.9 сая төгрөгөөс 1.5 хувиар буюу 1.4 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 1.0 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

/мянган төгрөг/

| Дансны код | Дансны нэр | Тайлант оны эхний үлдэгдэл | Тайлант оны эцсийн үлдэгдэл | Зөрүү |
|---|---|---|---|---|
| 1 | Бараа материал | 13,760.16 | 13,619.06 | 141.10 |
| 2 | Үндсэн хөрөнгө | 83,119.62 | 58,221.22 | 24,898.40 |
| 3 | Нийт хөрөнгийн дүн | 96,879.78 | 71,840.28 | 25,039.50 |
| 4 | Засгийн газрын хувь оролцоо | 96,879.78 | 71,840.28 | 25,039.50 |
| 5 | Өр төлбөр цэвэр хөрөнгө өмчийн дүн | 96,879.78 | 71,840.28 | 25,039.50 |

Бараа материалын данс 141.1 мянган төгрөгөөр буурсан нь үлдэгдлээс зарцуулалт хийсэнтэй холбоотой байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 24,898.4 мянган төгрөгөөр буурсан хөрөнгийн элэгдэлийн зардалтай холбоотой.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 25,039.5 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүн буурсантай холбоотой байна.

### 3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 91,992.1 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 91,992.1 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

#### 3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 91,991.3 мянган төгрөгийн,, урсгал үйл ажиллагаанд 91,952.2 мянган төгрөгийг зарцуулж, 39.1 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

#### 3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### 3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Онцолсон болон бусад асуудал гараагүй.

### 3.8 Аудитын гол асуудал

Зардлыг эдийн засгийн ангиллаар зарцуулаагүй, бэлэн мөнгөний гүйлгээний тайлан гаргаагүй, анхан шатны баримт дутуу бүрдүүлсэн байна.

### 3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

#### 3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 149 мэдээллээс хугацаандаа оруулсан 133 мэдээлэл, хугацаа хоцроосон 16 мэдээлэл байна.

**3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд**

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэхэд шилэн дансанд мэдээлэл байршуулахдаа хугацаа хоцроосон байгаад анхаарч ажиллах шаардлагатай байна.

**3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 1 зөвлөмж өгөгдсөнийг хэрэгжүүлсэн байна.

**3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал**

Соёлын төвийн өөрийн орлого бүрдүүлэлтийг анхаарах

**4. Аудитын илрүүлэлт**

Аудитаар нийт 35.9 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 31.2 сая төгрөгийн алдааг залруулж, 1.6 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 3.1 сая төгрөгийн зөрчилд зөвлөмж өгсөн.

**4.1 Залруулсан алдаа**

Нягтлан бодох бүртгэл хөтлөхдөө 31.2 сая төгрөгийн гүйлгээг мөнгөн сууриар бэлтгэсэн байсныг залрууллаа.

**4.2 Төлбөрийн акт**

Ажилтны цалингаас 0.1 сая төгрөгийн ХХОАТ суутгаагүй, 1.5 сая төгрөгийн ажил хавсарсны нэмэгдлийг илүү тооцож олгосон зэргийг нөхөн төлүүлэхээр төлбөрийн акт тогтоосон.

**4.3 Албан шаардлага хүргүүлээгүй**

**4.4 Зөвлөмж**

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дараалаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

***1. Нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой асуудал***

*1.1. <u>Илрүүлэлт:</u>*

- ✓ *1.0 сая төгрөгийн зардлыг эдийн засгийн ангиллаар зарцуулаагүй;*
- ✓ *0.9 сая төгрөгийн мөнгөн кассын тайлан бэлтгэн гаргаагүй;*
- ✓ *1.2 сая төгрөгийн гүйлгээний анхан шатны баримт бүрдэл дутуу байна*

*1.2. <u>Өгсөн зөвлөмж</u>:*

- ✓ *Сангийн сайдын 190 тоот тушаалыг хэрэгжүүлж ажиллах, зардлын зарцуулалт, төсвийн гүйцэтгэлд тавих дотоод хяналтыг сайжруулах;*
- ✓ *Төсвийн байгууллагын мөнгөн кассын үйл ажиллагааны журмыг мөрдөж ажиллах;*

- ✓ *Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.7-т "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно"; Татварын ерөнхий хуулийн 28.2-т "Татвар төлөгч ногдуулалт хийхдээ энэ хуульд заасан нийтлэг журмыг баримтлах бөгөөд холбогдох хуульд заасны дагуу орлого, зарлагын гүйлгээг бүртгэх, баримтжуулах, цахим төлбөрийн баримт үйлдэх, хэвлэх, илгээх, татварын бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд мэдээлэл дамжуулах зориулалт бүхий, нэгдсэн системд холбогдсон, стандартын шаардлага хангасан кассын машин, төхөөрөмж, компьютер, бусад дагалдах хэрэгслийг зориулалтын дагуу бүрэн ашиглаж, борлуулалтын мэдээллийг 14 хоногт багтаан татварын бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд илгээж, бүртгүүлнэ."; Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 14.3-т "Албан татвар суутган төлөгч хоорондын бараа борлуулсан, ажил гүйцэтгэсэн, үйлчилгээ үзүүлсэн тухай бүрд төлбөрийн баримт олгох бөгөөд уг баримтуудыг дангаар, эсхүл хамтатган нэмэгдсэн өртгийн албан татварын падаан үйлдэнэ."; гэж заасныг хэрэгжүүлж ажиллах;*

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 06 дугаар сарын 01 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

| д/д | Аудитад хамрагдсан байгууллагын нэр | Нийт алдаа, зөрчлийн | | Үүнээс | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Залруулга | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| 1. | Түдэвтэй сумын соёлын төв | 6 | 35.9 | 1 | 31.2 | 2 | 1.6 | | | 3 | 3.1 |
| | **Нийт** | **6** | **35.9** | **1** | **31.2** | **2** | **1.6** | | | **3** | **3.1** |